**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

**САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

# Баянхонгор аймгийн Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

**Аудитын код: БНА-2024/148/НА-СТА-ТШЗ**

| | |
|---|---|
| Цахим хуудас: www.audit.mn<br>Баянхонгор хот<br>2024.02.05 | Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор: Б.Мөнхбат<br>Утас: 99007576 Цахим хаяг: munkhbatb@audit.gov.mn<br>Ахлах аудитор М.Алтантуяа<br>Утас: 99061829 Цахим хаяг: altantuyam@audit.gov.mn<br>Аудитор: Б.Нарангэрэл<br>Утас: 99009293 Цахим хаяг: Narangerelb@audit.gov.mn<br>Цахим хуудас: www.audit.mn |

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

**1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ** ........ 3
**2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ** ........ 5
**3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА** ........ 10
**4. АУДИТЫН ТАЙЛАН** ........ 14
**4.1 Ерөнхий зүйл** ........ 14
**4.2 Материаллаг байдал** ........ 14
**4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт** ........ 15
**4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал** ........ 15
**4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт** ........ 15
**4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт** ........ 16
**4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал** ........ 16
**5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ** ........ 16
**5.1 Төлбөрийн акт** ........ 17
**6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ** ........ 18

**Товчилсон үгийн жагсаалт**

| | |
|---|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| ТӨБЗГ | Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар |

## 1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
310 дугаар байр, Лувсандансанжанцангийн
өргөн чөлөө 3 дугаар гудамж, Номгон 1 дүгээр баг,
Баянхонгор сум, Баянхонгор аймаг, 64101
Утас: (976) 70442584
Цахим шуудан:procurement. bayankhongor@audit.gov.mn

2024.01.31 № 2/01

танай__________-ны № __________-т

БАЯНХОНГОР АЙМГИЙН ОНЦГОЙ БАЙДЛЫН ГАЗРЫН ДАРГА, ХУРАНДАА Ж.АЛТАНГЭРЭЛ ТАНАА

### Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баянхонгор аймгийн Онцгой байдлын газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө,өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Баянхонгор аймгийн Онцгой байдлын газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан.

Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

### Асуудлыг онцолсон хэсэг

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна. Цаашид тус байгууллагын талаар чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй тул байгууллагын тасралтгүй байдлын талаар нөхцөл үүсээгүй гэж үзсэн болно.

### Аудитын гол асуудал

Тус байгууллага нь 2016 онд үүссэн авлагыг барагдуулаагүй, өмч хөрөнгөтэй холбоотой засварын ажлуудад өмч хамгаалах зөвлөлийн дүгнэлт гаргуулаагүй,

D- alban bichig 2022 A4 TOOT

5020051

худалдан авалтын и баримтад хяналт тавиагүй зэрэг зөрчил илэрсэн нь урьдчилан тогтоосон материаллаг байдлын түвшингээс хэтрээгүй.

**Бусад асуудлын хэсэг**

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 8 зорилтын хүрээнд 82 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 98.0 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна. Шалгагдагч байгууллагын санхүүгийн тайлангаас бусад үйл ажиллагааны тайлан, мэдээ, гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт зэрэг мэдээлэлтэй танилцсан. Танилцахад материаллаг буруу илэрхийлсэн зүйл илрээгүй.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР Б.МӨНХБАТ

D- alban bichig 2022 A4 TOOT

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

## 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

| Код | Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **26,806,564.42** | **79,368,355.26** |
| **33** | **АВЛАГА** | **0** | **33,944,990.84** |
| 33100 | Ажиллагчидтай холбогдсон авлага | 0 | 48,300.00 |
| **33500** | **Бусад авлага** | **0** | **33,896,690.84** |
| 33510 | Байгууллагаас авах авлага | 0 | 33,896,690.84 |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | **26,806,564.42** | **45,423,364.42** |
| 35300 | Бэлэн бүтээгдэхүүн | 55,346.00 | 55,346.00 |
| **35400** | **Хангамжийн материал** | **26,751,218.42** | **45,368,018.42** |
| 35410 | Бичиг хэргийн материал | 416,500.00 | 1,380,500.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 1,694,500.00 | 1,694,500.00 |
| 35430 | Сэлбэг хэрэгсэл | 7,015,000.00 | 16,245,000.00 |
| 35440 | Түлш, шатах тослох материал | 87.42 | 87.42 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 17,625,131.00 | 26,047,931.00 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **593,814,934.35** | **492,464,671.25** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | **593,814,934.35** | **492,464,671.25** |
| **39200** | **Биет хөрөнгө** | **505,596,101.08** | **404,379,838.02** |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 195,394,386.72 | 195,394,386.72 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | -19,363,822.72 | -23,504,778.40 |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 172,700,000.00 | 172,700,000.00 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | -73,544,444.54 | -102,952,777.82 |
| 39205 | Машин тоног төхөөрөмж(компьютер) | 396,367,626.64 | 335,780,836.56 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | -187,187,938.73 | -190,524,720.49 |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 42,983,793.00 | 33,975,776.12 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | -21,753,499.29 | -16,488,884.67 |
| **39300** | **Биет бус хөрөнгө** | **88,218,833.27** | **88,084,833.23** |
| 39301 | Програм хангамж | 1,580,000.00 | 1,030,000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | -1,122,166.73 | -706,166.77 |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 87,761,000.00 | 87,761,000.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **620,621,498.77** | **571,833,026.51** |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **620,621,498.77** | **571,833,026.51** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | **620,621,498.77** | **571,833,026.51** |
| 51100 | Засгийн газрын оруулсан капитал | 386,538,027.70 | 386,538,027.70 |
| 511001 | Улсын төсвийн оруулсан хөрөнгө | 386,538,027.70 | 386,538,027.70 |
| **51200** | **Хуримтлагдсан үр дүн** | **172,189,351.32** | **123,464,674.44** |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | -390,871,147.45 | 172,253,146.70 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | 563,060,498.77 | -48,788,472.26 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 61,894,119.75 | 61,830,324.37 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **620,621,498.77** | **571,833,026.51** |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **699,509,044.64** | **1,143,901,799.88** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **68,526,308.64** | **130,397,669.88** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 68,526,308.64 | 130,397,669.88 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 68,526,308.64 | 128,913,690.84 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 1,899,000.00 | 128,913,690.84 |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 66,627,308.64 | 00.00 |
| 120017 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө | 00.00 | 1,483,979.04 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **630,982,736.00** | **1,013,504,130.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 528,211,400.00 | 994,586,800.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 528,211,400.00 | 994,586,800.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 102,478,816.00 | 14,037,850.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 1,000,000.00 | 00.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 101,478,816.00 | 14,037,850.00 |
| **1330** | **Төсвийн захирагчдаас** | 292,520.00 | 4,879,480.00 |
| 133003 | Хөрөнгийн | 292,520.00 | 4,879,480.00 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **736,838,208.94** | **1,192,690,272.14** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **736,838,208.94** | **1,192,690,272.14** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 657,406,697.75 | 1,120,759,690.58 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 404,560,827.96 | 787,742,317.67 |
| 210101 | Үндсэн цалин | 335,054,818.96 | 507,579,077.60 |
| 210102 | Нэмэгдэл | 54,027,825.00 | 205,736,356.30 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 8,450,000.00 | 45,355,000.00 |
| 210104 | Урамшуулал | 7,028,184.00 | 29,071,883.77 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 50,769,005.66 | 98,138,776.37 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 34,468,110.54 | 66,583,168.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 3,817,155.37 | 7,796,318.56 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 3,518,199.48 | 6,403,705.20 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 815,037.32 | 1,577,780.42 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 8,150,502.95 | 15,777,804.19 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 23,955,382.65 | 26,001,268.86 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 2,361,408.65 | 2,745,160.86 |
| 210302 | Түлш, халаалт | 18,592,064.00 | 20,501,100.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 3,001,910.00 | 2,755,008.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 18,393,100.00 | 8,502,580.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 2,310,700.00 | 4,295,480.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 7,102,600.00 | 3,481,000.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 572,200.00 | 280,400.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 909,500.00 | 445,700.00 |
| 210408 | Бараа материал акталсны зардал | 7,498,100.00 | 00.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 343,200.00 | 168,200.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 343,200.00 | 168,200.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 5,966,000.00 | 2,859,900.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 5,966,000.00 | 2,859,900.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 403,250.00 | 8,515,192.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 00.00 | 8,306,492.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 72,200.00 | 35,400.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 173,250.00 | 96,000.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 157,800.00 | 77,300.00 |

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 153,015,931.48 | 188,831,455.68 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 44,854,038.54 | 83,628,513.54 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 108,161,892.94 | 105,202,942.14 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 79,431,511.19 | 71,930,581.56 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 2,750,000.00 | 911,760.00 |
| 213204 | Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал | 2,750,000.00 | 911,760.00 |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 5,892,222.73 | 71,018,821.56 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 5,892,222.73 | 64,874,971.56 |
| 213305 | Төвлөрүүлэх шилжүүлэг | | 6,143,850.00 |
| **2135** | **Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 70,789,288.46 | 00.00 |
| 213503 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 70,789,288.46 | 00.00 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **-37,329,164.30** | **-48,788,472.26** |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **-37,329,164.30** | **-48,788,472.26** |

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

| Код | Үзүүлэлт | ӨМНӨХ ОН | ТАЙЛАНТ ОН |
|---|---|---|---|
| **I** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)** | **632,589,216.00** | **1,103,641,650.00** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **1,899,000.00** | **95,017,000.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | **1,899,000.00** | **95,017,000.00** |
| **120004** | **Төсөв байгууллагын өөрийн орлого** | **1,899,000.00** | **95,017,000.00** |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 1,899,000.00 | 95,017,000.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **630,690,216.00** | **1,008,624,650.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | **528,211,400.00** | **994,586,800.00** |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 528,211,400.00 | 994,586,800.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | **102,478,816.00** | **14,037,850.00** |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 1,000,000.00 | 0 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 101,478,816.00 | 14,037,850.00 |
| **II** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **622,779,216.00** | **1,101,272,950.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **622,779,216.00** | **1,101,272,950.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **543,347,704.81** | **1,029,342,368.44** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **404,735,827.96** | **787,742,317.67** |
| 210101 | Үндсэн цалин | 335,229,818.96 | 507,579,077.60 |
| 210102 | Нэмэгдэл | 54,027,825.00 | 205,736,356.30 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 8,450,000.00 | 45,355,000.00 |
| 210104 | Урамшуулал | 7,028,184.00 | 29,071,883.77 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **50,769,005.66** | **98,138,776.37** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 34,468,110.54 | 66,583,168.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 3,817,155.37 | 7,796,318.56 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 3,518,199.48 | 6,403,705.20 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 815,037.32 | 1,577,780.42 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 8,150,502.95 | 15,777,804.19 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **23,955,382.65** | **26,001,268.86** |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 2,361,408.65 | 2,745,160.86 |
| 210302 | Түлш, халаалт | 18,592,064.00 | 20,501,100.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 3,001,910.00 | 2,755,008.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **10,509,500.00** | **5,147,700.00** |
| 210401 | Бичиг хэрэг | 1,925,200.00 | 940,600.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 7,102,600.00 | 3,481,000.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 572,200.00 | 280,400.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 909,500.00 | 445,700.00 |
| **2105** | **Нормативт зардал** | **343,200.00** | **168,200.00** |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 343,200.00 | 168,200.00 |

| Код | Үзүүлэлт | ӨМНӨХ ОН | ТАЙЛАНТ ОН |
|---|---|---|---|
| **2107** | **Томилолт, зочны зардал** | **5,966,000.00** | **2,923,900.00** |
| 210702 | Дотоод албан томилолт | 5,966,000.00 | 2,923,900.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **403,250.00** | **16,604,700.00** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 0 | 16,396,000.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 72,200.00 | 35,400.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 173,250.00 | 96,000.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 157,800.00 | 77,300.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **46,665,538.54** | **92,615,505.54** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 46,665,538.54 | 92,615,505.54 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **79,431,511.19** | **71,930,581.56** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | **2,750,000.00** | **911,760.00** |
| 213204 | Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал | 2,750,000.00 | 911,760.00 |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | **5,892,222.73** | **64,874,971.56** |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 5,892,222.73 | 64,874,971.56 |
| **2135** | **Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг** | **70,789,288.46** | **6,143,850.00** |
| 213503 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 70,789,288.46 | 6,143,850.00 |
| **III** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)** | **9,810,000.00** | **2,368,700.00** |
| **V** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)** | **9,810,000.00** | **2,368,700.00** |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **9,810,000.00** | **2,368,700.00** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | **9,810,000.00** | **2,368,700.00** |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 9,810,000.00 | 2,368,700.00 |
| **VI** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)** | **-9,810,000.00** | **-2,368,700.00** |
| **VIII** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)** | **0** | **0** |
| 101 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | 0 | 0 |
| 20 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 0 | 0 |

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|---|---|
| 2 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 328,802,027.70 | 61,894,119.75 | -390,871,147.45 | -175,000.00 |
| 3 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 328,802,027.70 | 61,894,119.75 | -390,871,147.45 | -175,000.00 |
| 5 | Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт | 57,736,000.00 | 0 | 0 | 57,736,000.00 |
| 9 | Тайлант үеийн үр дүн | 0 | 0 | 563,060,498.77 | 563,060,498.77 |
| 10 | 2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 386,538,027.70 | 61,894,119.75 | 172,189,351.32 | 620,621,498.77 |
| 11 | 2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл | 386,538,027.70 | 61,894,119.75 | 172,189,351.32 | 620,621,498.77 |
| 12 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 0 | 0 | 63,795.38 | 63,795.38 |
| 13 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 386,538,027.70 | 61,894,119.75 | 172,253,146.70 | 620,685,294.15 |
| 14 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт | 0 | -63,795.38 | 0 | -63,795.38 |
| 19 | Тайлант үеийн үр дүн | 0 | 0 | -48,788,472.26 | -48,788,472.26 |
| 20 | 2023 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл | 386,538,027.70 | 61,830,324.37 | 123,464,674.44 | 571,833,026.51 |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

| Код | Үзүүлэлт | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Хувь |
|---|---|---|---|---|---|
| **II** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **1,111,258,200.00** | **1,024,728,828.44** | 86,529,371.56 | 92.2 |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **1,111,258,200.00** | **1,024,728,828.44** | 86,529,371.56 | 92.2 |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **1,088,670,400.00** | **1,023,817,068.44** | 64,853,331.56 | 94.0 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **844,807,500.00** | **787,742,317.67** | 57,065,182.33 | 93.2 |
| 210101 | Үндсэн цалин | 484,995,000.00 | 507,579,077.60 | -22,584,077.60 | 104.7 |
| 210102 | Нэмэгдэл | 298,478,900.00 | 205,736,356.30 | 92,742,543.70 | 68.9 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 42,306,000.00 | 45,355,000.00 | -3,049,000.00 | 107.2 |
| 210104 | Урамшуулал | 19,027,600.00 | 29,071,883.77 | -10,044,283.77 | 152.8 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **105,601,000.00** | **98,138,776.37** | 7,462,223.63 | 92.9 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 71,808,600.00 | 66,583,168.00 | 5,225,432.00 | 92.7 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 8,448,100.00 | 7,796,318.56 | 651,781.44 | 92.3 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 6,758,500.00 | 6,403,705.20 | 354,794.80 | 94.8 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 1,689,600.00 | 1,577,780.42 | 111,819.58 | 93.4 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 16,896,200.00 | 15,777,804.19 | 1,118,395.81 | 93.4 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **26,308,500.00** | **26,001,268.86** | 307,231.14 | 98.8 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 2,597,500.00 | 2,745,160.86 | -147,660.86 | 105.7 |
| 210302 | Түлш, халаалт | 20,501,100.00 | 20,501,100.00 | 0.00 | 100.0 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 3,209,900.00 | 2,755,008.00 | 454,892.00 | 85.8 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **5,150,600.00** | **5,147,700.00** | 2,900.00 | 99.9 |
| 210401 | Бичиг хэрэг | 943,500.00 | 940,600.00 | 2,900.00 | 99.7 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 3,481,000.00 | 3,481,000.00 | 0.00 | 100.0 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 280,400.00 | 280,400.00 | 0.00 | 100.0 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 445,700.00 | 445,700.00 | 0.00 | 100.0 |
| **2105** | **Нормативт зардал** | **168,200.00** | **168,200.00** | 0.00 | 100.0 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 168,200.00 | 168,200.00 | 0.00 | 100.0 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | **2,923,900.00** | **2,923,900.00** | 0.00 | 100.0 |
| 210702 | Дотоод албан томилолт | 2,923,900.00 | 2,923,900.00 | 0.00 | 100.0 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **8,710,700.00** | **8,710,700.00** | 0.00 | 100.0 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 8,502,000.00 | 8,502,000.00 | 0.00 | 100.0 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 35,400.00 | 35,400.00 | 0.00 | 100.0 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 96,000.00 | 96,000.00 | 0.00 | 100.0 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 77,300.00 | 77,300.00 | 0.00 | 100.0 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **95,000,000.00** | **94,984,205.54** | 15,794.46 | 100.0 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 95,000,000.00 | 94,984,205.54 | 15,794.46 | 100.0 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **22,587,800.00** | **911,760.00** | 21,676,040.00 | 4.0 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | **22,587,800.00** | **911,760.00** | 21,676,040.00 | 4.0 |
| 213204 | Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал | 2,749,400.00 | 911,760.00 | 1,837,640.00 | 33.2 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 19,838,400.00 | 0 | 19,838,400.00 | 0.0 |
| **III** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | **1,111,258,200.00** | **1,024,728,828.44** | 86,529,371.56 | 92.2 |
| **31** | **УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | **1,016,258,200.00** | **929,711,828.44** | 86,546,371.56 | 91.5 |
| 310001 | Улсын төсвөөс санхүүжих | 1,016,258,200.00 | 929,711,828.44 | 86,546,371.56 | 91.5 |
| **35** | **ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС** | **95,000,000.00** | **95,017,000.00** | -17,000.00 | 100.0 |
| 350001 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 95,000,000.00 | 95,017,000.00 | -17,000.00 | 100.0 |
| **6** | **ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ** | **84** | **72** | | |
| **62** | **АЖИЛЛАГСАДЫН ТОО** | **42** | **36** | | |
| 620001 | Удирдах ажилтан | 1 | 1 | | |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 38 | 32 | | |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 3 | 3 | | |
| **65** | **ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ** | **42** | **36** | | |
| 650001 | Төрийн захиргааны албан хаагч (ТЗ) | 39 | 33 | | |
| 650009 | Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ) | 3 | 3 | | |

## 2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

/төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх он | Тайлант он |
|---|---|---|---|
| | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | |
| **I** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **102,478,816.00** | **14,037,850.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **102,478,816.00** | **14,037,850.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **33,588,527.54** | 7,894,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | | 7,894,000.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | | 7,894,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **33,588,527.54** | 0.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | **33,588,527.54** | 00.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 68,890,288.46 | 6,143,850.00 |
| 213305 | Улсын төсвөөс олгосон санхүүжилт, төвлөрүүлэх шилжүүлэг | 68,890,288.46 | 6,143,850.00 |
| **II** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 102,478,816.00 | 14,037,850.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 102,478,816.00 | 14,037,850.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 1,000,000.00 | 00.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 101,478,816.00 | 14,037,850.00 |
| 131106 | Төсвийн урамшуулал | | 00.00 |
| **IV** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)** | | **0.00** |
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | | 0.00 |
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | | 0.00 |

# 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

## 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Баянхонгор аймгийн Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар нь “Иргэдэд газар, барилга, хот байгуулалт, нийтийн аж ахуйн болон газрын кадастрын талаарх төрөөс үзүүлэх үйлчилгээг ил тод, шударга, хөнгөн шуурхай үзүүлж, тэдний эрүүл, аюулгүй таатай орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлэхэд оршино” гэсэн эрхэм зорилгынхоо хүрээнд үйл ажиллагааныхаа зорилтыг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд

- Хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, газар зохион байгуулалтын төлөвлөгөөг баримтлан барилга байгууламж барих газрын зөвшөөрөл, техникийн нөхцөлийг хууль тогтоомж, дүрэм журамд нийцүүлэн олгож ажиллана.
- Газрыг эдийн засгийн эргэлтэд оруулж, ашиглалт, үр өгөөжийг нэмэгдүүлэх зорилгоор иргэн болгонд газар өмчлүүлэх ажлыг эрчимжүүлнэ.
- Геодези зураг зүйн орчин үеийн техник, тоног төхөөрөмжийн тусламжтайгаар аймгийн хэмжээнд газар эзэмшигч, ашиглагч, өмчлөгч бүрийн анхан шатны бүртгэлийн хувийн хэрэг болон мэдээллийн санг бүрдүүлнэ.
- Газрын харилцааны талаар болон барилгын хяналтын улсын бүртгэлтэй холбогдсон төрийн үйлчилгээг нэг цэгээс, иргэн, аж ахуйн нэгж байгууллагад хөнгөн шуурхай хүртээнэ.
- Барилга угсралтын ажлын чанар, зураг төслийн боловсруулалт, техникийн бичиг баримтын бүрдүүлэлт зэргэд барилгын норм дүрэм, стандартын шаардлагын дагуу хяналт тавьж ажиллана.

### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт *ороогүй* байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Дотоод аудит/аудиторын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Баянхонгор аймгийн Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын 2023 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллага нь Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын даргын 2023 оны 09 сарын 18-ны өдрийн А/157 дугаар тушаалаар баталсан "Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг"-ийг үйл ажиллагаандаа ашиглаж, санхүүгийн тайлан бэлтгэхдээ мөрдөж ажиллаж байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Баянхонгор Онцгой байдлын газрын 2023 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 571,833.0 мянган төгрөг буюу 7.9 хувиар *буурсан* байна.

*Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт*

/мянган төгрөгөөр/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | | Эцсийн үлдэгдэл | | Өөрчлөлт | |
|---|---|---|---|---|---|---|
| | Дүн | Эзлэх хувь | Дүн | Эзлэх хувь | Дүн | Хувь |
| А | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 |
| ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН | 26,806.6 | 4.3% | 79,368.4 | 13.9% | 52,561.8 | 196.1% |
| Мөнгөн хөрөнгө | - | 0.0% | - | 0.0% | - | 0.0% |
| Авлага | - | 0.0% | 33,945.0 | 5.9% | 33,945.0 | 0.0% |
| Урьдчилгаа | - | 0.0% | - | 0.0% | - | 0.0% |
| Бараа материал | 26,806.6 | 4.3% | 45,423.4 | 7.9% | 18,616.8 | 69.4% |
| ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН | 593,814.9 | 95.7% | 492,464.7 | 86.1% | (101,350.3) | -17.1% |
| Үндсэн хөрөнгө | 896,786.8 | 144.5% | 826,642.0 | 144.6% | (70,144.8) | -7.8% |
| Хуримтлагдсан элэгдэл | (302,971.9) | -48.8% | (334,177.3) | -58.4% | (31,205.5) | 10.3% |
| **Нийт хөрөнгө** | 620,621.5 | 100.0% | 571,833.0 | 100.0% | (48,788.5) | -7.9% |
| Өр төлбөр | - | 0.0% | - | 0.0% | - | 0.0% |
| Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/ | 620,621.5 | 100.0% | 571,833.0 | 100.0% | (48,788.5) | -7.9% |
| **Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн** | 620,621.5 | 100.0% | 571,833.0 | 100.0% | (48,788.5) | -7.9% |

Авлагын дансны үлдэгдэл 33,945.0 мянган төгрөг байгаа нь нийгмийн даатгалын шимтгэлийн авлага 48.3 мянга, 2023 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдэх төсөл арга хэмжээний орон нутагт эрх шилжсэн санхүүжилтийн захиалагчийн хяналтын зардал болох 33,896.7 мянган төгрөгийг авлагаар тусгасантай холбоотой байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 45,423.4 мянган төгрөг болж 18,616.8 мянган төгрөгөөр өссөн нь төсвийн худалдан авалтаар 49,157.6 мянган төгрөгийн бараа материалыг худалдан авч, Газар зохион байгуулалт геодези зураг зүйн газраас 4,879.5 мянган төгрөгийн өртөг бүхий бусад хангамжийн материалыг үнэ төлбөргүй хүлээн авч, бичиг хэргийн материалаас 8,267.7 мянга, аж ахуйн материал данснаас 1,291.7 мянга, сэлбэг хэрэгсэл данснаас 3,865.0 мянга, түлш шатах тослох материал данснаас 17,590.2 мянга, бусад хангамжийн материал данснаас 4,405.7 мянга, нийт 35,420.3 мянган төгрөгийг зарцуулсан нь голлох нөлөө үзүүлжээ.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 826,642.0 мянган төгрөг болж 70,144.8 мянган төгрөгөөр буурсан нь төсвийн худалдан авалтаар 2,368.7 мянга, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2023 оны 03 дугаар сарын 18-ны өдрийн 116 дугаар тогтоолоор аймгийн Мэргэжлийн хяналтын газраас бүтцийн өөрчлөлтөөр үнэ төлбөргүй шилжүүлэн авсан 1,142.5 мянган төгрөгийн балансын үнэ бүхий 20 нэр төрлийн хөрөнгийг хүлээн авсан бөгөөд Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2023 оны 12 дугаар сарын 20-ний өдрийн А-1/2483 дугаар албан бичгээр 73,997.5 мянган төгрөгийн балансын үнэ бүхий тавилга эд хогшил, тоног төхөөрөмжийг данснаас хасах шийдвэр гарсны дагуу акталж, бүртгэлээс хассан байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 571,833.0 мянган төгрөг болж 48,788.5 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүнгээр хуримтлагдсан 48,788.5 мянган төгрөгөөр буурсантай холбоотой байна.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2023 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 864,962.6 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 864,962.6

мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас цалин хөлс болон нэмэгдэл урамшлын зардлыг 246,295.6 мянга, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл зардлыг 31,200.5 мянга, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийг 6,817.5 мянга, нэг удаагийн тэтгэмж урамшууллын зардлыг 7,287.8 мянган төгрөгөөр өсгөж, байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 4,041.3 мянга, хангамж, бараа материалын зардлыг 40,707.5 мянга, нормативд зардлыг 7831.8 мянга, эд хогшил, урсгал засварын зардлыг 79,250.0 мянга, томилолт, зочны зардлыг 22,155.1 мянган төгрөгөөр бууруулж, 1,111,258.2 мянган төгрөгөөр баталсан байна.

Энэ нь Баянхонгор аймгийн Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар нь Монгол улсын Засгийн газрын 2023 оны 241 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай" тогтоолоор албан хаагчдын цалин хөлс нэмэгдсэнээс шалтгаалсан байна.

### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд улсын төсвийн санхүүжилтээр 994,546.8 мянга, үндсэн үйл ажиллагааны орлогоос 95,000.0 мянган төгрөгийн эх үүсвэрийг бүрдүүлснээс урсгал үйл ажиллагаанд 1,024,728.8 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,024,728.8 мянган төгрөг буюу 92.2 хувьтай байгаа нь цалин хөлс болон нэмэгдэл урамшлын зардлаас 57,065.2 мянга, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл 7462.2 мянга, байр ашиглалттай холбоотой тогтмол зардал 307.2 мянга, хангамж, бараа материалын зардал 2.9 мянга, бараа үйлчилгээний бусад зардал 15.8 мянга, тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмжээс 19,838.4 мянга, нэг удаагийн тэтгэмж урамшууллын зардлаас 1,837.6 мянган төгрөгөөр зарцуулаагүй нь голлох нөлөөг үзүүлж байна.

*Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл*

/мянган төгрөгөөр/

| д/д | Хөтөлбөр, арга хэмжээ | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Биелэлт |
|---|---|---|---|---|---|
| 1 | **71504 Газрын зураглал, кадастр** | **1,111,258,200.00** | **1,024,728,828.44** | **86,529,371.56** | **92.2%** |
| 2 | 80101 Үндсэн үйл ажиллагаа | 985,168,400.00 | 920,330,862.90 | 64,837,537.10 | 93.4% |
| 3 | 80226 Байр ашиглалтын үйлчилгээ | 8,502,000.00 | 8,502,000.00 | 0.00 | 100.0% |
| 4 | 80802 Ажил олгогчоос олгох тэтгэмж | 22,587,800.00 | 911,760.00 | 21,676,040.00 | 4.0% |
| 5 | 82404 Барилгын техник хяналт | 95,000,000.00 | 94,984,205.54 | 15,794.46 | 100.0% |

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т "нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна" гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд 14,037.9 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлж, бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамжид 7,894.0 мянган төгрөгийг зарцуулж, 6143.9 мянган төгрөгийн буцаан төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### 3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Тайлант онд тус байгууллага нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.3-д заасны дагуу шууд худалдан авалт хийсэн байна.

Тус байгууллага нь дохиолол хамгаалалтын гэрээг Даяар хүч ХХК-тай 6,600.0 мянга, Шунхлай ХХК-тай шатахууны мөнгөн талоныг зээлээр худалдан авахаар шууд гэрээ байгуулж ажилласан байна.

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Баянхонгор аймгийн Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар нь 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллах зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Б.Нарангэрэл гүйцэтгэж, чанарын хяналтыг ахлах аудитор М.Алтантуяа, газрын дарга, тэргүүлэх аудитор Б.Мөнхбат нар тус тус хэрэгжүүлсэн.

Баянхонгор аймгийн Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлгэх хүсэлтийг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 11 дүгээр сарын 23-ны өдрийн 663 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

### 4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2021 оны жилийн

эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 736,838.2 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 11,052.6 мянга, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 7,736.8 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор 2023 оны байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 307.2 мянга буюу 1.2 хувь, бичиг хэргийн зардлыг 2.9 мянга буюу 0.1 хувиар нийт 310.1 мянган төгрөгийн хэмнэлт бий болгосон байна.

### 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Нийцлийн асуудлаар илэрсэн зөрчилд 1 албан шаардлага хүргүүлж ажиллаа.

#### 4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд шилэн дансны нэгдсэн цахим хуудаст мэдээлбэл зохих хуулийн 6.4.5 “Цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого зарлагын мөнгөн гүйлгээ”-д заасан 1,028,601.1 мянган төгрөгийн 20 мэдээлэл, 6.4.8 ”Төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах шийдвэрийн мэдээлэл” -д заасан 76,742.5 мянган төгрөгийн 116 мэдээллийг хугацаанд нь бүрэн мэдээлж, 6.4.5 “Цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого зарлагын мөнгөн гүйлгээ”-д заасан 51,184.7 мянган төгрөгийн орлогын 4 гүйлгээ, 6.4.8 ”Төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах шийдвэрийн мэдээлэл” -д заасан 20,440.6 мянган төгрөгийн 6 гэрээг байршуулаагүй байна.

*Шийдвэрлэсэн нь*: Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.5-д заасан мэдээллийг бүрэн байршуулж, зөрчлийг арилгах албан шаардлага өгөв.

### 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Тайлант хугацаанд завсар үеийн аудит хийгдээгүй болно.

### 4.5.1 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Ж.Өсөхбаяр гүйцэтгэж аудитаар 5,940.0 мянган төгрөгийн 3 зөрчил илрүүлж, зөрчлийг арилгах 4,440.0 мянган төгрөгийн 2 албан шаардлага, алдаа зөрчлийг дахин давтан гаргахгүй байх 1,500.0 мянган төгрөгийн 1 заалт бүхий зөвлөмжийг хүргүүлснийг бүрэн биелүүлсэн талаар тус байгууллагаас 2023 оны 05 дугаар сарын 05-ны өдрийн 234 дугаартай албан бичгээр ирүүлэн, FAS программд хэрэгжилтийг мэдээлж ажилласан байна.

*Хүснэгт 4 Төлбөрийн акт,* албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

| Үзүүлэлт | Өмнөх аудитын үзүүлэлт | | Биелэлт | | |
|---|---|---|---|---|---|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Хувь |
| Төлбөрийн акт | - | - | - | - | - |
| Албан шаардлага | 2 | 4,440.0 | 2 | 4,440.0 | 100% |
| Зөвлөмж | 1 | 1,500.0 | 1 | 1,500.0 | 100% |
| **Нийт дүн** | **3** | **5,940.0** | **3** | **5,940.0** | **100%** |

### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

байхгүй

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 1,258.8 мянган төгрөгийн 2 алдаа[1] илэрснээс аудитын явцад залруулав. Үүнд:

1. Тус байгууллагад Мэргэжлийн хяналтын байгууллагаас балансаас балансад шилжүүлсэн хөрөнгийг анх бүртгэхдээ 83.3 мянган төгрөгөөр дутуу бүртгэсэн. Анхны өртгөө нөхсөн 9 нэр төрлийн хөрөнгийг дахин үнэлж 341.9 мянган төгрөгөөр бүртгэхдээ дансны бичилтийг буруу хийсэн байгаа нь УСНББОУС-17 үндсэн хөрөнгө, мөн үнэлгээ ба хуваарилалт гэсэн батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна.
2. Тайлант хугацааны нярвын тайлан нь санхүүгийн тайлангаас орлого, зарлага 833.6 мянган төгрөгөөр илүү илэрхийлэгдсэн нь УСНББОУС-12 Бараа материал, иж бүрэн байх батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна.

Аудитаар нийт 85,682.7 мянган төгрөгийн 3 зөрчил[2] илэрснээс 1,052.4 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт, 84,630.3 мянган төгрөгийн зөрчлийг арилгах 2 албан шаардлага өгсөн.

[1] Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

[2] Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Нийт илрүүлсэн алдаа, зөрчлөөс 1,052.4 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа болон зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс 10,000.2 мянган төгрөгөөр бага тул Өөрчлөлтгүй дүгнэлт өглөө.

**5.1 Төлбөрийн акт**

5.1.1 Байгууллагын дотоод хяналтыг хэрэгжүүлээгүйгээс хугацаа давхацсан 256.0 мянган төгрөгийн 4, хугацааг сунгах шийдвэр гараагүй байхад илүү олгосон 412.0 мянган төгрөгийн 3 томилолт, томилолтын хуудасгүй олгосон 128.0 мянган төгрөгийн 1, томилолтын замын зардлыг хүчин төгөлдөр бус баримт хавсаргасан 99.2 мянган төгрөгийн 1, олговол зохих томилолтын хоногоос илүү олгосон 157.2 мянган төгрөгийн 2 томилолт байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, Засгийн газрын 2019 оны "Төрийн албан хаагчид нөхөх төлбөр олгох журам"-ын 2.4 “Албан томилолтоор ажилласан хоногийн тоог албан томилолтоор ажиллуулах шийдвэрт тэмдэглэсэн хуанлийн хоногоор тооцож гаргана. Албан томилолтоор явсан, буцаж ирсэн өдрийг нэгтгэн нэг хоногт тооцно”, 2.8 “ Томилолтын хугацааг хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр хэтрүүлсэн тохиолдолд хэтрүүлсэн хугацааны байр, хоолны зардлыг олгохгүй” гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

*Шийдвэрлэсэн нь*: Хяналт хэрэгжүүлээгүй холбогдох буруутай албан тушаалтнуудаар буцаан төлүүлж, төлбөрийн актыг тогтоов.

**5.2 Албан шаардлага**

5.2.1 Мөнгөн хөрөнгийн харилцах данснаас 709.8 мянган төгрөгийн гүйлгээг И-баримтгүй шилжүүлсэн, мөн 12,295.2 мянган төгрөгийн и баримтыг харилцагч байгууллагаас илүү шивсэн байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1. "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.6.”Албан татвар суутган төлөгч төлбөрийн баримтыг өөр дүнгээр олгосон, эсхүл төлбөрийн баримт олгохоос татгалзсан бол албан татвар төлөгч энэ талаар татварын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад, эсхүл харьяа татварын албанд нэн даруй мэдэгдэх үүрэгтэй.”, Сангийн сайдын 2017 оны 347 тоот тушаалаар батлагдсан “Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягтыг нөхөн заавар”-ын 6.5. Төлбөрийн баримт “Төлбөрийн баримт нь бараа, ажил, үйлчилгээний төлбөр, тооцоо хийгдсэнийг нотлох анхан шатны цаасан болон цахим баримт юм. Төлбөрийн баримтад борлуулагч, худалдан авагчийг таних тэмдэг, татвар төлөгчийн дугаар, төлбөр тооцоо хийгдсэн он, сар, өдөр, бараа, ажил, үйлчилгээний нэр, код, тоо хэмжээ, үнэ, татварын дүнг тусгана. Төлбөрийн баримтыг цахим гарын үсэг эсхүл тусгай нууцлалын QR кодоор баталгаажуулах бөгөөд Монгол Улсын Стандарт MNS 6529:2015 “Татварын нэгдсэн системд ашиглах төлбөрийн баримтын ерөнхий шаардлага”-д заасан загварын дагуу бүртгэлийн машинаар хоёр хувь үйлдэнэ” гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

*Шийдвэрлэсэн нь*: Худалдан авалтын 709.8 мянган төгрөгийн и баримтыг 2024.02.20-ны дотор нөхөн шивүүлэх, илүү шивсэн 12,295.2 мянган төгрөгийн зөрчлийг арилгах, цаашид худалдан авалтын и баримтад тавих хяналтыг сайжруулж ажиллах албан шаардлага хүргүүлэв.

5.2.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн хүрээнд хуулийн 6.4.5-д заасан 5.0 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 51,184.7 мянган төгрөгийн 4 гүйлгээг мэдээлээгүй, 6.4.8-д заасан төсөв, өмч хөрөнгө, мөнгө зарцуулах шийдвэртэй холбоотой цахилгаан, дулаан, цэвэр бохир ус, шатахуун нийлүүлэх, захиалагчийн хяналт хэрэгжүүлэх 20,440.6 мянган төгрөгийн 3 гэрээг шилэн дансны нэгдсэн цахим хуудаст байршуулаагүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.5 дахь “Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр”, 6.4.8 “Бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр“ гэсэн заалтуудыг зөрчиж байна.

*<u>Шийдвэрлэсэн нь</u>*: Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.5-д заасан 51,184.7 мянган төгрөгийн 4 мэдээлэл, 6.4.8-д заасан 20,440.6 мянган төгрөгийн 6 мэдээллийг бүрэн байршуулж, зөрчлийг арилгах албан шаардлага өгөв.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

**Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл** /мянган төгрөгөөр/

| Алдааны товч утга | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үүнээс | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Залруулсан | | Залруулаагүй | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Санхүүгийн тайланд буруу бүртгэсэн | 1 | 425.2 | | | 1 | 425.2 | 1 | 425.2 | | |
| Санхүүгийн тайланд бүртгээгүй | 1 | 833.6 | 1 | 833.6 | | | 1 | 833.6 | | |
| Дүн | **2** | **1,258.8** | **1** | **833.6** | **1** | **425.2** | **2** | **1,258.8** | | |

## Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Тайлант хугацааны томилолтын зардлыг тулгахад байгууллагын дотоод хяналтыг хэрэгжүүлээгүйгээс хугацаа давхацсан 256,000 төгрөгийн 4, хугацааг сунгах шийдвэр гараагүй байхад илүү олгосон 412,000 төгрөгийн 3 томилолт, томилолтын хуудасгүй олгосон 128,000 төгрөгийн 1, томилолтын замын зардлыг хүчин төгөлдөр бус баримт хавсаргасан 99,200 төгрөгийн 1, олговол зохих томилолтын хоногоос илүү олгосон 157,200 төгрөгийн 2 томилолт байна.. | 1 | 1,052.4 | 1 | 1,052.4 | | | | |
| Мөнгөн хөрөнгийн харилцах данснаас 709.8 мянган төгрөгийн гүйлгээг И-баримтгүй шилжүүлсэн, мөн 12,295.2 мянган төгрөгийн и баримтыг харилцагч байгууллагаас илүү шивсэн байна. | 1 | 13,005.0 | | | 1 | 13,005.0 | | |
| **Нийт дүн** | **2** | **14,057.4** | **1** | **1,052.4** | **1** | **13,005.0** | | |

## Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Шилэн дансны тухай хуультай холбоотой зөрчил | | | | | | | | |
| Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн хүрээнд хуулийн 6.4.5-д заасан таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 6,155.1 мянган төгрөгийн орлогын 1 гүйлгээг мэдээлээгүй байна. | 1 | 71,625.3 | | | 1 | 71,625.3 | | |
| Дүн | **1** | **71,625.3** | | | **1** | **71,625.3** | | |

------------oOo-------------